



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 1/780

Номгон

Аймгийн Засаг даргын өрхийн эрүүл мэндийн
төвүүдтэй 2021 онд байгуулсан гэрээ дүгнэх
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/05 дугаар тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн Засаг даргын Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан жил бүрийн гэрээний биелэлтийг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Гишүүд: Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Эрүүл мэнд, Нийтийн биеийн тамир, спортын асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Салбарын төсвийн төлөвлөлт, санхүүгийн бүртгэл мэдээлэл, тайлангийн нэгтгэл хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар, эрсдэл хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, эмнэлгийн тусlamж үйлчилгээтэй холбоотой халдвартай хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Хүүхдийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Сувилахуйн болон хөнгөвчлөх тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн

Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны төлөөлөл

Иргэний нийгмийн төлөөлөл

601210833

D:\2021\Zakhiramj-2021 он\Захирамж-2021 он+.docx

2.

Нарийн бичгийн дарга: Нөхөн үржихүй, өсвөр үе, залуучуудын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн

2.Гэрээний хэрэгжилтийг үнэлэх үйл ажиллагааг жил бүрийн 12 дугаар сарын 28-ны дотор багтаан зохион байгуулахыг Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээний хэрэгжилтийг удирдамжийн дагуу зохион байгуулж, тайлагнахыг Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэст тус тус үүрэг болгосугай.

3.Гэрээг дүгнэсэн үнэлгээний дүнг Аймгийн Засаг даргад танилцуулахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Б.Наранбаяр/-т даалгасугай.

